

## ЦАХИМ ХЭВЛЭЛ, НИЙГМИЙН СҮЛЖЭЭНИЙ ОНЦЛОГ БА МОНГОЛ ХЭЛ

### FEATURES OF ONLINE JOURNALISM, SOCIAL MEDIA AND MONGOLIAN LANGUAGE

Д.Боролзой

*Түлхүүр үг:* Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хэвлэл, нийгмийн сүлжээ, монгол хэл, интернэт хэл шинжлэл

*Keywords:* Media, online journalism, social network, Mongolian language, Mongolian internet linguistics

**Товч агуулга:** Уг өгүүлэлд хүн төрөлхтөний мэдээлэл харилцааны нэн шинэ хэрэгсэл болох интернэтэд суурилсан нийгмийн сүлжээ, цахим сэтгүүл зүй зэргийн онцлог болон эдгээр нь монгол хэлний өнөөгийн байдалтай хэрхэн холбогдож байгаа талаар өгүүлжээ. Түүнчлэн цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба нийгмийн сүлжээний адил төстэй болоод ялгаатай талуудынх нь тухайтодорхой өгүүлсэн байна. Цахим орчинд л бол үзэл бодлын хувьд ч, хэвлэн нийтлэхийн хувьд ч, эх хэлээрээ буруу зөв бичих тухайд чэрх чөлөөтэй, дур дураараа, хамаа намаагүй байж болох мэтээр ойлгосон байдаг нь ташаа ойлголт юм. Өөрөөр хэлбэл аль нь хувийн эрх чөлөөний талбар, аль нь олон нийтийн өмнө хариуцлага хүлээдэг, бодлоготой хандах ёстой орчин гэдгийн зааг ялгааг тодорхой ойлгох ёстой. Мэдээллийн нь сайтууд нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болохынхоо хувьд тодорхой дэг журамтай, хуульд захирагддаг, монгол хэлний бичгийн хэлний хэм хэмжээг баримтлах ёстой “албан ёсны харилцаа”-ны орчин байдаг бол сайтад сэтгэгдэл бичих, эсвэл нийгмийн сүлжээнд хүмүүс өөр хоорондоо харилцах нь харьцангуй хувийн шинж чанартай, бичгийн хэлний хэм хэмжээг заавал чанд баримтлах шаардлагагүй “хувийн харилцаа”-ны орчин юм. Тийм учраас албан ёсны харилцааг дүрэм журмаар зохицуулах, удирдах боломжтой бол хувийн харилцааг удирдах боломж, шаардлага байхгүй гэж ойлгож болно.

Хоорондын зайнаас үл хамааран мэдээлэл солилцох өргөн талбар болох интернэт эдүгээ энэ дэлхийн хэдэн тэрбум хэрэглэгчдийг холбосон аварга сүлжээ болжээ. Интернэт хэрэглэгчдийн тоо 1994 онд ердөө дөрвөн сая байсан бол 2010 оны байдлаар нэг тэрбум 966 сая болсон байна. Харин 2015 оны 11-р сарын 30-ны байдлаар дэлхийн 7 тэрбум 259 сая хүний 3 тэрбум 366 сая нь интернэт хэрэглэж байгаа статистик мэдээ байна (World Internet Users and 2015 Population Stats, 2015). Энэ бол дэлхийн нийт хүн амын 46,4 хувь нь юм. Энэхүү өсөлтийг 2000 оны интернэт хэрэглэгчдийн тоотой харьцуулахад 832,5 хувь өссөн үзүүлэлт ажээ.

Огноо	Хэрэглэгчдийн тоо	Дэлхийн хүн амд эзлэх хувь
1994 он	4 сая	-
1995 оны 12-р сар	16	0,4 %
1996 оны 12-р сар	36	0,9 %
2000 оны 12-р сар	361	5,8 %
2003 оны 12-р сар	608	9,7 %
2005 оны 12-р сар	1 тэрбум 18 сая	15,7 %
2008 оны 12-р сар	1 тэрбум 565 сая	23,3 %
2010 оны 6-р сар	1 тэрбум 966 сая	28,7 %
2015 оны 11-сарын 30	3 тэрбум 366 сая	46,4 %

(эх сурвалж: [www.internetworldstats.com](http://www.internetworldstats.com))

Интернэт үүсэн бий болсон түүхийн хувьд анх 1960-аад онд АНУ-ын Батлан хамгаалах яам Тэргүүлэх эрдэм шинжилгээний төслийн агентлаг (Advanced Research Project Agency /ARPA/) хэмээх газрыг байгуулжээ. Энэхүү байгууллагын гол зорилго нь цөмийн зэвсгийн цохилтын үед цэрэг дайны зорилгоор холбоо харилцааг найдвартай аюулгүй байлгахад оршиж байв. Энэ үеэс

эхлэн дээрх зорилгоор Америкт байгаа компьютеруудын аюулгүй байдлыг хангах ARPANET хэмээх сүлжээг бий болгож эхэлсэн гэдэг. Хүйтэн дайны үед цөмийн цохилт болоход энэхүү сүлжээний нэг хэсэг нь өртөхөд бусад хэсэг нь ажиллах чадвартай байхаар ARPANET сүлжээг бүтээсэн ажээ. Технологийн энэхүү зарчим нь хожим интернэт бий болоход хамгийн гол үүргийг гүйцэтгэсэн юм. Энэ төсөл тун амжилттай хэрэгжсэн бөгөөд 1969 онд ердөө дөрөвхөн компьютерийг хооронд нь холбосон бол 1974 онд 62 компьютерийг холбосон сүлжээ болжээ. Эхлээд зөвхөн батлан хамгаалах чиглэлийн компьютерууд холбогдож байсан бол аажим аажмаар төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын компьютерууд холбогдож эхэлсэн байна. Өөрөөр хэлбэл энэхүү ARPANET сүлжээ нь 1983 онд цэргийн хэрэгцээнд зориулсан MILNET, их дээд сургуулиудын эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зориулсан INTERNET хэмээн хоёр салжээ.

Хэрэглэгчдийн хоорондын зайнаас үл хамааран мэдээлэл солилцох өргөн талбар болох интернэтийн сүлжээ нь эдүгээ хэдэн тэрбум хүнийг хооронд нь холбож өгдөг аварга том хэрэгсэл болжээ. Ийнхүү интернэт хэмээх зүйл нь хүн төрөлхтний туулж ирсэн уламжлалт зан заншил, соёл иргэншилд цоо шинэ эрин үеийг авчирч бидний ахуй амьдралд гүн гүнзгий өөрчлөлт, шинэ харилцааг бий болгож байна. Интернэтийн хөгжлийн энэхүү маш хурдацтай, басхүү амжилттай явагдсан “нэг дэх шалтгаан нь АНУ-ын Батлан хамгаалах яамны зохион бүтээсэн энэхүү технологи нь найдвартай байдлыг хамгийн дээд зэргээр хангасан байдаг. Өөрөөр хэлбэл интернэтэд холбогдсон компьютеруудын нэг хэсгийн ажиллагаа зогссон байхад интернэт сүлжээ нь автоматаар маршрутаа өөрчлөн ямар ч саадгүйгээр ажиллана гэсэн үг юм. Хоёр дахь шалтгаан нь интернэт хүний байгалиас заяасан хоорондоо харилцах гол хэрэгцээг хангаж байгаад оршино. Хорьдугаар зууны хүн төрөлхтний түүх бол хүмүүс хоорондоо хурдан шуурхай, найдвартай, чанартай харилцах технологийг хөгжүүлж ирсэн түүх гэж хэлж болно” (Интернэт, 2006: 13-14).

Орчин үед интернэт нь хүмүүсийн өдөр тутмын хэрэглээ болжээ. Хүмүүсийн хоорондоо харилцан ярилцах, мэдээлэл солилцох, мэдээлэл хүлээн авах, түүнийгээ хуваалцах гээд энэ бүхнийг интернэт нь харилцааны бусад хэрэгслээс хамаагүй давуу байдлаар хүргэж чаддаг болжээ. Ийнхүү интернэт нь цаасан хэвлэлийг халснаар хүмүүсийн хоорондоо бичгээр харилцаж байгаа мэдээллийн нэлээд томоохон хэсэг нь энд төвлөрдөг болсон байна.

### **Монголын интернэтийн хөгжлийн тойм**

Интернэтийн ашиг тус өгүүлж баршгүй их юм. Үүгээр бид шинэ мэдээллийг хурдан шуурхай авч байна, худалдаа хийгээд төлбөр тооцоо хийгдэж байна, зар сурталчилгаа явагдаж байна, захиа солилцож хоорондоо утсаар хүртэл ярилцаж байна, мэдлэгээ хуваалцаж байна, үзэл бодлоо илэрхийлж байна, сургалт явагдаж байна гэх мэтээр түүний боломж асар өргөн билээ. Эрт цагт мэдээлэл дамжуулахад ном голлох үүрэг гүйцэтгэж байлаа, дараа нь телевиз, харин одоо энэ байр суурийг интернэт баттай эзлэн авчээ. Нүүдэлчин монголчууд хэзээнээсээ шинэ зүйлд сониуч, тэр хэрээрээ шинэ зүйлийг өөриймшүүлэн хэрэглэхдээ гаргамгай. Анх монголчууд интернэт хэмээх зүйлтэй хэрхэн холбогдсон түүхтэй товчхон танилцъя.

Монгол улс интернэтэд 1994 оноос эхэлж холбогджээ. 1996 онд интернэт хэрэглэгчдийн тоо Монголд ердөө 500 гаруйхан байсан бол одоо албан газар, өрх бүр шахуу интернэтэд холбогдож хувийн болоод албаны бүхий л ажил хэрэг үүгээр өрнөдөг болжээ. “1994 онд “Мэдээллийн харилцаа ББХК” нь Монголд анх удаа интернэтийн үйлчилгээг явуулж эхэлсэн нь одоогийн “Датаком” компанийн эхлэл, Монгол улсын интернэтэд холбогдох цорын ганц гарц нь байлаа. Энэ үед интернэтэд өдөрт 2 удаа холбогдож и-мэйлийн дамжуулалт хийдэг байв. 1995 оны 12 сараас газрын станц суурилуулснаар интернэтэд онлайнаар холбогдох боломж бий болсон. Улмаар “Мэдээллийн харилцаа ББХК” нь “Датаком” ХХК болон өргөжиж, Монголд анх интернэтийг нэвтрүүлэх болон интернэтийн төрөл бүрийн үйлчилгээ хэрэглээг Монголд бий болгох тал дээр маш чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Тухайн үед Америкийн элчин сайд Монголд нийлүүлж байсан шар тосны орлогоос Монголын хамгийн хүнд салбаруудад санхүүгийн зээл, тусламж үзүүлэх сан байгуулсан байв. Энэ сангаас “Датаком” ХХК 50 000 ам.долларыг 4.8 хувийн хүүтэйгээр зээлэн авч интернэтийн үйлчилгээнийхээ эхлэлийг тавьсан байдаг. 1996 оны 1-р сарын 17-нд Монгол улсад интернэт нэвтэрснийг албан ёсоор зарлаж, интернэтийн нээлтийн

ажиллагаанд ерөнхийлөгч П.Очирбат болон төр засгийн томоохон төлөөлөгчид оролцож байлаа. Энэхүү нээлтэн дээр Монгол улсын төрийн далбааг цахим байдлаар намируулан, төрийн дууллаа эгшиглүүлж, интернэтэд холбогдсон 10 компьютер дээр “Датаком” компанийн инженер мэргэжилтнүүд NBA, CNN зэрэг дэлхийд алдартай сайтуудыг нийтэд дэлгэн үзүүлж байлаа. Тухайн үед интернэтийн техник, технологи дөнгөж нэвтэрч байсан тул эрс тэс уур амьсгалтай Монгол орны өвлийн ид хүйтэнд шөнөдөө газрын антенн хөлдөж интернэт тасрах ч үе байдаг байжээ. Интернэтээ тасалчихгүйн тулд үсний сэнсийг антеннаа тойруулан байрлуулж тогонд залгаад гадуур нь шуудайгаар боож хөлдөхөөс хамгаалах үе ч байв. 1996 онд интернэт хэрэглэгчдийн тоо Монголд 500 гаруйхан байв. Тэр үед Монгол улсад интернэт болон компьютерийн талаар мэдлэг, мэдээлэл дутмаг байсан хэдий ч Д.Энхбат захирлаар удирдуулсан “Датаком” ХХК шинэ техник, технологийг маш амжилттай нэвтрүүлж, одоо та бид үүний үр шимийг хүртэн гэртээ компьютертэй, интернэттэй болж, гэрээсээ гаралгүйгээр дэлхий дахины мэдээллийн ертөнцөд аялан суух болсон билээ” (Энхбат, 2008).

2013 оны байдлаар Монголд “интернэтийн бүртгэлтэй хэрэглэгчид 762 мянга болж өмнөх оноосоо 36,7 хувиар өссөн” (Цагаан ном, 2014: 29) гэсэн албан ёсны дүн мэдээ байна. 1000 хүнд ногдох интернэт хэрэглэгчдийн тооны хувьд 202 байна. 1000 хүнд ногдох интернэт хэрэглэгчдийн тоогоор Сингапур 870, БНСУ 858 гэсэн тоогоор тэргүүлдэг бол манай хойд хөрш ОХУ 482 байдаг ажээ (Монгол улсын өрсөлдөх чадварын тайлан, 2015: 127). Сүүлийн жилүүдэд интернэтэд суурилсан “агуулга” буюу “content”-ын хэрэглээ хүч түрэн олон нийтийг өргөн хүрээнд хамрах боллоо. Интернэтэд суурилсан Фэйсбүүк (Facebook), Твиттер (Twitter), Юүтүб (Youtube), Инстаграм (Instagram) зэрэг олон нийтийн сүлжээнд монголчууд нэгдэн өргөнөөр ашиглаж байна. 2013 оны мэдээгээр “дэлхийн хүн амын 16,8 хувь нь Фэйсбүүк хэрэглэж байна. Түүнтэй зэрэгцээд Монгол улсын хүн амын 20,1 хувь нь фэйсбүүк хэрэглэгч болжээ. Хэрэглэгчийн тоо 640 мянгад хүрч өмнөх оноос 53 хувиар өссөнөөс 580 мянга нь Улаанбаатар хотын хэрэглэгч байна”(Цагаан ном, 2014: 30). Монгол дахь интернэт хэрэглэгчдийн өсөлтийг харвал:

Огноо	Хэрэглэгчдийн тоо
1996	500 гаруй
2005	9015
2006	10880
2007	14622
2008	42001
2013	762000

(эх сурвалж: [www.n20.mn](http://www.n20.mn))

Интернэтийн бүх нийтийн хэлэнд үзүүлж буй нөлөө:

Товчоор хэлэхэд интернэт нь цахим шуудан (e-mail), чат (chat), вэб сайт (web site), нийгмийн сүлжээ (social network) зэрэгхэрэгслүүдээр дамжин монгол хэлэнд нөлөөлж байна. Үүнээс гадна интернэттэй үл хамааран хэлэнд нөлөө үзүүлж байгаа хэрэгсэл бол гар утасны мессежийн харилцаа юм. Интернэтийн орчинд болж буй монгол хэлний хувьсал хөгжлийг судлахдаа дан ганц “интернэт орчин” гэлгүй “цахим орчин” хэмээн нэрлэх нь энэхүү гар утасны мессежийн харилцаанд интернэт орчинд тохиолдож буйтай мөн адилхан асуудал өрнөөд буйг нь хэлсэн хэрэг юм. Өөрөөр хэлбэл энэ нь интернэтээс гадна компьютерт суурилсан харилцаа (computer mediated communication) хэмээх бас нэгэн өөр харилцааг хэлж буй хэрэг юм. Интернэт нь дэлхий нийтийг хамарсан хэрэглээ болж түгэхээс өмнө буюу 1990-ээд оны эхээр компьютерт суурилсан харилцаа хэмээх нэр томъёо бий болж, энэ талаарх судалгаа хийгдэж иржээ. Тэгэхээр интернэтээс ч өмнө буюу компьютерийн хэрэглээгээр, мөн гар утсаар мессеж бичиж харилцах болсноор цахим орчны хэлний хувьсал хөгжлийн асуудал эхэлсэн юм.

Гар утас, компьютер

Интернэтийн хамгийн хүчтэй хэрэгсэл болох нийгмийн сүлжээ хүчээ авахаас өмнө компьютерийн хэрэглээ, гар утасны мессежээр хэлэнд бий болоод байгаа өнөө цагийн “зовлон

бэрхшээл” болох цахим орчны монгол хэлний хувьсал хөгжлийн асуудал бий болж эхэлжээ. Монголчуудын компьютерийн хэрэглээний хувьд дараах статистик байна. Ашиглагдаж буй компьютерийн дэлхийд эзлэх хувиар Монгол нь 0.03 бол 1000 хүнд ногдох компьютерийн тоогоор 172 (Монгол улсын өрсөлдөх чадварын тайлан, 2015: 127) байгаа нь 916 ногдож буй БНСУ, 894 ногдож буй Сингапуртай харьцуулахад тийм ч өндөр үзүүлэлт биш юм.

Интернэт хэл шинжлэл хэмээх судалгааны чиглэлийг анхлан томьёолсон хэл шинжээч Дэвид Кристал гар утасны мессежийн харилцааны талаар “Txtng: The gr8 db8” (Texting: the great debate) хэмээх залуусын хоорондоо мессежээ товчлон бичдэг тэр хэлбэрээр нэрлэсэн бүтээлдээ “гар утасны зурвасаар дамжин илэрч байгаа хэлний өөрчлөлтийг авч үзсэн. Судалгааны материалд гар утасны зурвасуудыг цуглуулан, бичлэг, бичвэр дээр задлал хийхийн зэрэгцээ зурвас илгээж буй хүний нас, ажил мэргэжлийн онцлог, амьдарч буй нийгмийн орчин нөхцлөөс шалтгаалж олон сонирхолтой үйлдэл ажиглагдаж байгааг харуулсан. Түүний ажигласнаар мессеж бичлэгт үгийн эгшгийг товчлох байдал (texting-txtng), тооны дуудлагыг ашиглан үсэг тоо хольж хэрэглэх (great-gr8), эхний үсгээр товчлох (TTUL-talk to you later), нүүрний хувирал илтгэсэн төрөл бүрийн дүрсийг ашиглах байдал түгээмэл байсан. Д.Кристал үзэхдээ энэ бүх зүйл нь цоо шинэ үзэгдэл биш бөгөөд олон жилийн турш англи хэлэнд байсаар ирсэн гэдгийг жишээ татан үзүүлсэн” (Энхмаа, 2015: 14) байна.

Гар утас хэмээх зүйлийг анх Жон Ф.Митчель (John F. Mitchell), Мартин Күүпэр (Martin Cooper) нар 1973 онд зохион бүтээжээ. Анхны гар утас болох Моторола-гийн энэ утас 2 кг жинтэй байсан гэдэг. Ийнхүү Америкийн “Моторола” компани үүрэн телефоны шинэ эрин үеийг нээсэн байна. Монголчуудын хувьд 1996 онд анх гар утас хэмээх орчин үеийн дэвшилтэт технологитой танилцсан юм. Өнөөдрийн байдлаар манай улсад Мобиком, Скайтел, Юнител, Жи-мобайл гэсэн дөрвөн оператор компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хэрэглэгчдийн тооны хувьд хэрэглэгчдийн тооноосоо ч давсан буюу 4 саяд хүрчээ (Цагаан ном, 2014: 27). 1000 хүнд ногдох үүрэн телефон хэрэглэгчдийн тоо Монголд 1207 байдаг бол энэ үзүүлэлтээр Казахстан 1858, ОХУ 1829-ээр тус тус тэргүүлдэг ажээ (Монгол улсын өрсөлдөх чадварын тайлан, 2015).

Интернэтэд шууд холбогдох боломжтой болтлоо хөгжсөн өнөөгийн ухаалаг утас бий болохоос өмнөх утсаар ярихаас гадна хоорондоо харилцах боломжийг олгодог байсан үйлчилгээ бол мессежийн үйлчилгээ юм. Өнөөгийн цахим орчинд өрнөөд буй монгол хэлний хөгжил, хувьслын эхэн үеийн тодорхой жишээг харуулах орчин бол гар утасны мессежийн хэрэглээний орчин юм. Мессеж гэдэг нь аливаа хүн бусдад хүргэх мэдээллээ 90-160 тэмдэгтэд багтаан текстэн хэлбэрээр бичиж илгээдэг бөгөөд энэхүү хязгаарлагдмал хэмжээнээс нь болоод мөн л богино хэмжээнд аль болох олон утга санаа, мэдээлэл буюу үгийг дамжуулах хэрэгцээ үүсэн бий болдог. Богино хэмжээнээс гадна хурдан шуурхай бичих хэрэгцээ шаардлага байдаг нь мессежийн хэрэглээнд утга санаа, сэтгэл хөдлөлөө илэрхийлэхдээ үгийг товчлох, хураах, дүрс ашиглах зэрэг хэрэгцээг бий болгодог байна.

Монголчууд гар утас ашиглаж эхэлснээр л үгийг товчлон бичих хэрэгцээ гэнэт бий болоогүй юм. Бүр эрт дээр үеэс уйгуржин монгол бичиг хэрэглэж байхад л таталган буюу үгийг товчлон хурааж бичих уламжлал бидэнд байсан бол хувь хүмүүс лекц, хичээл зэргээ хурдан шуурхай тэмдэглэн авах хэрэгцээнээс үгийг товчлон бичиж байсан байдаг. Энэ уламжлалаа монголчууд мессежийн харилцаандаа сэргээн хэрэглэсэн билээ. Монголчуудын гар утсаарх мессежийн бичгийн харилцаанд гадаад үгийг хэрэглэх нь түгээмэл харагддаг. Ж: hi, bye, lol г.м. Мөн байнга идэвхтэй давтан хэрэглэдэг үгсийг товчлох /бну-байна уу/, /снү-сайн уу/ г.м. Тэрчлэн сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх /кк-инээж байгааг илэрхийлэх/. Мессежийн хэрэглээнд кирилээр бичих технологийн боломжийг бүрэн шийдээгүйгээс латин үгсийг ашиглан бичих нь одоо ч түгээмэл байна.

### **Цахим сэтгүүл зүй**

Аливаа шинэ зүйл бий болохдоо дэвшилтэт зүйлийг авчрахын хамтаар бас өөрийн шинэ зовлон бэрхшээлийг үүсгэх нь бий. Үүний нэгэн тодорхой жишээ бол цахим сэтгүүл зүй юм. Цахим сэтгүүл зүйн орчинд монгол хэлний эвдрэл, басхүү хөгжил хувьсалд нөлөөлөх зүйл арвинтохиолдож байна. Мэдээллийн технологийн хувьсгалаас шалтгаалан анхлан радио, тэгээд

сонин, сүүлдээ телевизүүд голлох үүрэгтэй мэдээллийн хэрэгслүүд байсан бол сүүлийн үед цахим сэтгүүл зүй улам эрч хүчээ аванилүү олныг хамарч байна.

Интернэт хэмээх зүйл бий болсноор л цахим сэтгүүл зүй гэдэг шинэ салбар үүсэх нөхцлийг бүрдүүлжээ. Дэлхийд анх АНУ-ын Охайо мужийн “Columbus Dispatch” сонин 1980 онд цахим хувилбараа түгээж эхэлснээр хамгийн анхны электрон хэвлэл бий болсон гэж үздэг бол Монголд анх “Датаком” ХХК интернэтийн сүлжээг оруулж ирэн [www.mol.mn](http://www.mol.mn) гэсэн портал сайтыг ажиллуулж эхэлснээр цахим сэтгүүл зүйн үндсийг тавьсан гэж үздэг байна. Энэхүү Монголын анхны портал сайтад өдөр тутмын, долоо хоног тутмын гол хэвлэлүүд болон МОНЦАМЭ агентлагийн мэдээллийг монгол, англи хэлээр хөрвүүлэн тавьж байснаас гадна өөрсдөө мэдээний редакци байгуулан ажиллаж байжээ.

Эдүгээ Монголд цахим мэдээллийн хэрэгслийн тоо жил ирэх бүр нэмэгдсээр байна. Монголын хэвлэлийн хүрээлэнгийн судалгаагаар 2012 онд 30, 2013 онд 68, 2014 онд 100 гаруй мэдээллийн вэб сайт ажиллаж байгаа бөгөөд жилд 40 гаруй мэдээллийн хэрэгсэл шинээр нээгдэж байгаагийн дийлэнх нь цахим мэдээллийн хэрэгслүүд байдаг байна. Харин эсрэгээрээ хэвлэмэл хэвлэл буюу сонин, сэтгүүлийн тоо жилээс жилд буурч байгаа хандлага ажиглагдаж байна. “2013 оны нэгдүгээр улирлын байдлаар манайд 555 хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байв. Эдгээрийн дотроос Монголын сайтуудын холбоо, сайтуудын ассоциацид бүртгэлтэй, өөрийн гэсэн редакцитай 68 сайт байна” (Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мониторингийн судалгаа, 2013: 1).

Цахим хэвлэл буюу интернэт нь өнөө үеийн хамгийн шуурхай мэдээллийн хэрэгсэл болохын хувьд олон нийтэд мэдээлэл түгээхээс гадна мэдээллийг хүлээж авч байгаа иргэд ч бас байр сууриа илэрхийлэх, санал бодлоо уралдуулах зэрэг идэвхтэйгээр мэдээлэл хүлээн авдаг учраас “мэдээллийн төдийгүй харилцааны үүргийг нэгэн зэрэг агуулж байдгаараа маш том нөлөөг үзүүлдэг” (Болд-Эрдэнэ, 2009: 9) хүчирхэг хэрэгсэл гэж хэлж болно. Тэгэхээр энэ нь нэг талаараа иргэдэд мэдээлэл өгч, нөгөө талаараа тэдний дуу хоолойг илүү хүртээмжтэй, шуурхай байдлаар хүргэх, нийгмийн амьдралд татан оролцуулах эргэх холбоог үүсгэдэг. Үүнийг сэтгүүл зүйд “иргэний сэтгүүл зүй” гэдэг” байна.

Нэг талаас мэдээллийг хүлээн авах, нөгөө талаас түүнд оролцох боломж олгодгоороо цахим мэдээллийн хэрэгсэл бусдаасаа ялгардаг. Энэ нь мэдээллийн хэрэгсэл талаас мэдээ мэдээллийг нийтлэх, хүлээн авагч буюу уншигч талаас “comment” буюу “сэтгэгдэл” бичих маягаар оролцож байна гэсэн үг юм. Ийм учраас олон нийтийн хэлний боловсролд хүчтэй нөлөөлж байдгийн хувьд цахим орчинд хэвлэн нийтлэх нь яг л бичмэл, хэвлэмэл ном хэвлэл нь бичгийн хэлний ямар хэм хэмжээг баримтлах ёстой байна, түүнийг баримтлах ёстой байдаг. Өөрөөр хэлбэл албан ёсны харилцаа болохын хувьд хэвлэлийн редакциуд үүнд хариуцлагатай хандах ёстой. Харин цахим орчинд энэ талын асуудлыг үл тоосон, хариуцлагагүй хандлагаас болж зөв бичгийн дүрмийн алдааг баримтлахгүй бичих, бичгийн хэлний хэм хэмжээг сахихгүй байх, гадаад үгийг замбараагүй хэрэглэх явдал элбэг байна. Олон нийтэд мэдээлэл түгээдэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болохын хувьд цахим сэтгүүл, хэвлэмэл сонин сэтгүүл ч яг адилхан монгол хэлний бичгийн хэлний хэм хэмжээг ягштал баримтлах үүрэгтэй билээ.

УИХ-аас шинээр батлан гаргаж 2015 оны 7 сарын 1-нээс хэрэгжиж эхэлж буй “Монгол хэлний тухай хууль”-д ч энэ талын харилцааг зохицуулсан заалт байдаг. Тухайлбал, уг хуулийн 19-р зүйлийн 1-д “Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага дараах үүрэг хүлээнэ” гээд 19.1.1-д “монгол хэлний зөв бичих дүрэм, орчин цагийн утга зохиолын монгол хэлний хэм хэмжээг чанд баримтлах”, 19.1.2-г “сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны мэргэжлийн ур чадварын шалгалтад монгол хэл, бичгийн мэдлэгийн шалгуур тогтоосон байх” гэсэн байна.

Интернэт орчны эрх чөлөөний тухайд манайд байгаа нэгэн эргэлзээтэй ойлголтын талаар саналаа хэлье. Энэ бол цахим орчинд л бол үзэл бодлын хувьд ч, хэвлэн нийтлэхийн хувьд ч, эх хэлээрээ буруу зөв бичих тухайд ч тэр эрх чөлөөтэй, дур дураараа, хамаа намаагүй байж болох мэт ойлголт түгээмэл байдаг нь ташаа юм. Өөрөөр хэлбэл аль нь хувийн эрх чөлөөний талбар, аль нь олон нийтийн өмнө хариуцлага хүлээдэг, бодлоготой хандах ёстой орчин бэ гэдгийн зааг ялгааг

бид тодруулах ёстой. Мэдээллийн нь сайтууд нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болохынхоо хувьд тодорхой дэг журамтай, хуульд захирагддаг, монгол хэлний бичгийн хэлний хэм хэмжээг баримтлах ёстой “албан ёсны харилцаа” явагддаг орчин байдаг бол харин сайтад сэтгэгдэл бичих, нийгмийн сүлжээнд хүмүүс хоорондоо харилцах нь харьцангуй хувийн шинж чанартай, бичгийн хэлний хэм хэмжээг заавал чанд баримтлах шаардлагагүй “хувийн харилцаа”-ны орчин юм. Тийм учраас албан ёсны харилцааг зохицуулах, удирдах боломжтой бол хувийн харилцааг удирдах боломж болоод шаардлага аль аль нь байхгүй билээ.

### **Нийгмийн сүлжээ**

Хэдийгээр мэдээлэл түгээдэг ч гэлээ олон нийтийн мэдээллийн хэрэгслээс ялгаатай хувийн харилцааны орчин бол “соошэл нэтворк” (social network, social media) буюу “нийгмийн сүлжээ” юм. Ердөө арваадхан жилийн өмнө бид өдөр тутмын мэдээллээ радио, телевиз, өдөр тутмын сонин, сэтгүүлээс авч байсан бол харин өнөөдөр нийгмийн сүлжээ нь мэдээлэл, харилцааны хамгийн хамгийн том сүлжээ болон өргөжин хөгжиж, дэлхийн хэмжээнд хамгийн олон хүнийг хамарсан харилцаа холбоо, мэдээ мэдээллийн хэрэгсэл болон хувирчээ. Нийгмийн сүлжээ нь үнэхээр богино хугацаанд олныг хамарч чадсан байдаг. Тухайлбал, нийгмийн сүлжээ нь 50 сая хэрэглэгчидтэй болохын тулд ердөө 4 жилийг зарцуулсан бол энэ хэмжээний хэрэглэгчтэй болохын тулд радио 38 жил, телевиз 13 жилийг зарцуулжээ.

Нийгмийн сүлжээ гэдэг нь интернэтэд суурилсан нийгмийн харилцаа юм. Гэхдээ нийгмийн сүлжээг нийгмийн гэхээсээ илүүтэй олон нийтийн мэдээ мэдээллийн сүлжээ гэж ойлгож болно. Энэхүү олон нийттэй харилцах сүлжээнд хүмүүс олон төрлийн вэб хуудсуудаар өөр хоорондоо холбогдон харилцахын хамтаар мэдээллээ солилцдог. Интернэтийн технологи хөгжихийн хэрээр нийгмийн сүлжээний хөгжлийн үндэс тавигдсан түүхтэй. Интернэтийн хуучин технологийн үед интернэтээс мэдээлэл авахдаа зөвхөн унших, вэб сайтад өөрийн сэтгэгдлээ үлдээх боломжгүй байсан бол хөгжлийн дараагийн үедээ хүмүүс хоорондоо харилцаа холбоо тогтоох, аливаа вэб сайтад сэтгэгдэл үлдээх, өөрийн цахим блог үүсгэх гэх мэт бүх үйлдэл нь нэг вэб орчинд шилжсэн нь том давуу тал, шинэ дэвшил болсон юм.

Нийгмийн сүлжээний вэб сайтуудад агуулагдаж буй мэдээ мэдээллүүд нь зүгээр нэг “амьгүй харилцаа” биш эсрэгээрээ хүмүүсийн хоорондын идэвхтэй “амьд харилцаа”-гаар үүсдэг харилцаа холбооны шинэ үзэгдэл юм. Мөн хуучны мэдээ мэдээллийн хэрэгслийг (телевиз, радио, сонин, сэтгүүл) нэг дор нэгтгэсэн учир нэг дор олон хэрэглэгчдэд хүрч массад нөлөөлөх боломжтойгоороо мэдээллийн хүчтэй хэрэгсэл юм. Энэ хэрээрээ ч өнөө цагт нийгмийн сэтгэл зүйд, хэлний хувьсал хөгжилд шууд нөлөөлж байна. Тухайлбал, телевиз болон сонины мэдээг үзсэн тухайн уншигч, үзэгчид нь л хардаг бол нийгмийн сүлжээ буюу жишээ нь, Фэйсбүүк, Твиттерт хэдий хэмжээний хэрэглэгчид хүрээлж байна тэр бүрт мэдээллээ бусадтай хуваалцаж түгээж чаддаг. Ингэснээр хэрэглэгчдийг өөрсдийг нь мэдээллийн сүлжээнд идэвхтэй оролцуулж байна гэсэн үг юм.

Монголчууд ч гэсэн нийгмийн сүлжээний энэхүү хурдтай хөгжлөөс хоцроогүйгээр барахгүй хэдийн идэвхтэй оролцогчид болсонбилээ. Өнөөдөр Монгол улсад нийгмийн сүлжээг идэвхтэй ашиглах явдал улам нэмэгдсээр байгаа бөгөөд хувь хүмүүсээс гадна төрийн бус байгууллагууд, улс төр, боловсрол гэх мэт салбарын төрийн байгууллагууд, бизнесийн салбарынхан түлхүү ашигласаар байна. Улс төрийн салбарынхан ихэвчлэн твиттерийг, бизнесийнхэн фэйсбүүкийг түлхүү хэрэглэж байгаа бол телевизээр гарсан мэдээлэл, сонинд гарсан нийтлэлүүд ч цахим хувилбарт шилжиж нийгмийн сүлжээний хэрэгслүүдээр олон мянган хүнд хүрч байна. Орон зай, цаг хугацааны хувьд нийгмийн сүлжээнд хүн бүр өөрийн хүссэн мэдээллээ хурдан шуурхай түгээх боломжтой хэдий ч мэдээллийн үнэн зөв, алдаатай эсэхэд нь хяналт тавих ямар ч боломжгүй байдаг нь түүний сул тал болно. Тийм учраас хяналт багатай энэ орчинд монгол хэлний эвдрэлд нөлөөлөх муу нөлөө нь харьцангуй их байна. Монголчуудын түгээмэл хэрэглэдэг зарим нэг нийгмийн сүлжээний хэрэгслийг танилцуулъя.

Фэйсбүүк /Facebook/: Фэйсбүүк нь дэлхийн хамгийн олон хэрэглэгчтэй нийгмийн сүлжээний сайт юм. Фэйсбүүк нь орон зай, хил хязгаарыг үл хамааран найз нөхөд, гэр бүл, бүр танихгүй хүмүүстэйгээ ч хамтран ажиллах, бизнес хийх, харилцах, бичгэн болон зурган мэдээллээ

солилцох, харилцан суралцахад таатай нөхцлийг бүрдүүлдэг харилцааны хэрэгсэл юм. Фэйсбүүк хаяг нээн ашиглах нь хэн бүхэнд нээлттэй.

Фэйсбүүкийг Марк Цукэрбэрг хэмээх залуу Харвардын их сургуульд сурдаг хажуу өрөөнийхөө компьютерийн чиглэлээр суралцдаг найзын хамт санаачлан бүтээж 2004 оны 2 сарын 4-нд анх ажиллуулж эхэлжээ. Анхлан найзуудын хүрээнд байнга холбоотой байж болохуйц гүүр маягийн вэб сайт бүтээхээр зорьж байсан бөгөөд 2006 он хүртэл энэхүү сайт нь зөвхөн Харвардын дотоод хүрээнд л ажилласаар 2006 оны 9 сараас хойш дэлхий дахинд нээлттэйгээр ажиллаж эхэлсэн түүхтэй. Эдүгээ дэлхий нийтийн хэмжээнд өдөрт 1 тэрбум хүн Фэйсбүүкийг идэвхтэй ашигладаг бөгөөд энэ нь дэлхийн хүн амын долоон хүн тутмын нэг нь юм. 2015 оны 9 сарын байдлаар Фэйсбүүкт бүртгэлтэй хэрэглэгч 2 тэрбум давсан ба үүнээс идэвхтэй хэрэглэгч нь 1 тэрбум 550 сая байна<sup>1</sup>. Монголын хувьд хамгийн сүүлийн мэдээгээр Фэйсбүүкийн 1 сая гаруй хэрэглэгч бүртгэлтэй байгаа бөгөөд энэ нь Монголын гурван хүн тутмын нэг нь юм. Гэхдээ энэ нь хараахан 1 сая хэрэглэгчтэй гэсэн үг биш бөгөөд нэг хүн олон Фэйсбүүкийн хаягтай байдгийг тооцох хэрэгтэй. Үүнээс Фэйсбүүк нь Монголд хичнээн олон хүнийг хамарч чадсан байна, энэ хэрээрээ монгол хэлний хөгжил хувьсалд төчнөөн хүчтэй нөлөөлөх боломжтой нь харагдана. Фэйсбүүкт хэрэглэгчид агуулга (контент) буюу хувийн тэмдэглэл, мэдээ мэдээлэл, зураг оруулахаас гадна сэтгэгдэл бичиж, хоорондоо чаатаар бичгээр харилцдаг учраас хэлтэй холбон судлах арвин баримт хэрэглэгдэхүүн энд үлддэг.

Твиттер /Twitter/: “Твиттер” буюу “Жиргээ” хэмээх бичил блогийн үйлчилгээ үзүүлдэг нийгмийн сүлжээний энэхүү сайтыг анх АНУ-ын Жек Дорси, Эвэн Виллиамс, Биз Стөун, Ноа Гласс нар 2006 оны 3 сард бүтээж 2006 оны 7 сараас нийтэд хүрч эхэлжээ. “Твиттерийн уг үндсийг Одео гэгч подкастинг явуулдаг компанийн захирлуудын зөвлөл өдөржин хамт сууж янз бүрийн санаа оноо гаргасны эцэст олжээ. Ноён Жек Дорси анх жижиг бүлэг хамт олны хүрээнд мессежээр зэрэг холбогдох санааг гаргажээ. Төслийн анхны нэр нь *Twttr* байсан бөгөөд Фликр болон Америкийн текст мессежийн 5 үсэгтэй кодоос санаа авсан байна. Зохион бүтээгчид анх 10958 гэсэн богино кодыг зохиосон боловч дараа нь тогтооход амар хэмээн 40404 болгож сольжээ. Төслийн ажил анх 2006 оны 3 сарын 21-нд Дорси Пасификийн стандарт цагаар 9.50 минутанд “дөнгөж твттрээ янзалж байна” гэх анхны твиттерийн мессежээ бичсэнээр эхэлжээ” (Бат-Ирээдүй, 2011). Англиар шувууд жиргэхийг *tweet* гэх ба *Twiiter*-ийг *Жиргээ*, *tweet* бичихийг *жиргээх*, бичдэг хүнийг *жиргээчин* хэмээн орчуулан нэрлэж байна. Өөрөөр хэлбэл твиттерийн хэрэглэгчид нь шувуудын жиргээ мэтээр богино богино хэмжээгээр буюу 140 тэмдэгтэд багтаан үзэл бодол, мэдээллээ бусдад түгээн, түүнийг нь бусад нь хуваалцаж илүү олон хүнд түгээн жиргэх гэх мэтээр өөр хоорондоо холбогддог дэлхийн хамгийн олон хэрэглэгчидтэй нийгмийн сүлжээний сайт болжээ.

Эдүгээ твиттер дэлхийн хэмжээнд 2015 оны 3-р сарын 25-ны байдлаар 645750000 бүртгэлтэй хэрэглэгчтэй бөгөөд үүнээс идэвхтэй хэрэглэгч нь 289 сая байна. Хэрэглэгчдийн тоо өдөрт 135000-аар нэмэгдэж, сард твиттер хуудсаар 190 сая хүн зочилж, өдөрт 58 сая, минут тутам 9100 жиргээ хийгдэж байна<sup>2</sup>.

Монголын твиттер хэрэглэгчдийн тооны хувьд яг нарийн тооцсон статистик байхгүй бөгөөд барагцаалж болно. Өнөөгийн байдлаар (2016.01.05) твиттерт хамгийн олон дагагчтай монгол хүн бол УИХ-ын гишүүн Х.Баттулга (@BattulgaKh) юм. Түүний дагагчдын тоо 167000 бөгөөд түүний араас сумогийн их аварга Д.Дагвадорж (@Asashoryu) 149000, УИХ-ын дарга З.Энхболд (@enkhboldz) 128000, ерөнхийлөгч Ц.Элбэгдорж (@elbegdorj) 112000 дагагчдаар тус тус удаалж байна. Эндээс харахад твиттерт бүртгэлтэй хэрэглэгч 100-120 мянга орчим, үүнээс идэвхтэй нь 30-40 мянган орчим байх магадлалтай байна. Монголын хувьд ажиглахад 20-40 насны залуучууд хамгийн идэвхтэй, сэтгүүлчид, улс төрийнхөн зэрэг нийгмийн нэлээд идэвхтэй хэсгийнхэн жиргээнд байдаг бөгөөд насны хувьд 20-60 насныхан твиттерт байдаг.

<sup>1</sup> [https://en.wikipedia.org/wiki/List\\_of\\_virtual\\_communities\\_with\\_more\\_than\\_100\\_million\\_active\\_users](https://en.wikipedia.org/wiki/List_of_virtual_communities_with_more_than_100_million_active_users)

<sup>2</sup> <http://www.statisticbrain.com/twitter-statistics/>

Твиттерийн нэг удаа жиргэх хэмжээ нь 140 тэмдэгтэд багтах ёстой байдаг онцлогоос нь шалтгаалж твиттерийн орчинд товчлон бичих, монгол хэлний зөв бичих зүй болоод бичгийн хэлний хэм хэмжээ алдагдах, харь үгийн хэрэглээ, латин галигийн асуудал гээд хэлний бэрхшээлтэй зүйлс арвин тулгардаг учраас хэл шинжээчдийн судалгааны нэгэн чухал объект болж байна.

Блог /Blog/: “Блог” гэдэг нь “Web log” гэсэн үгийн товчлол бөгөөд “вэб тэмдэглэл” гэсэн утгатай. “Вэб лог” гэдэг нэр томъёог анх Америкийн Жорн Баргэр гэдэг хүн 1997 оны 12 сарын 17-нд гаргажээ. “Вэблог”-ийг товчилж “блог” гэж хэлэх болсноор энэ нэршил үүссэн байна. Блогийн гол ач холбогдол нь энэ зүйлийг хэрэглэгч хэн бүхэн хэвлэн нийтлэгч болж чаддагт оршдог. Өөрөөр хэлбэл энгийн нэг хувь хүн өөрийн гэсэн вэб сайт буюу “хэвлэл мэдээллийн хэрэгсэл”-тэй болж өөрийн үзэл бодол, мэдээ мэдээ мэдээллээ энэ дэлхийн хаанаас ч үзэх боломжтойгоор олны хүртээл болгож байна гэсэн үг юм. Энэхүү “хэвлэл мэдээллийн хэрэгсэл”-ээрээ дамжуулан онлайн сонин, сэтгүүл гаргах, ажил мэргэжилтэйгээ холбоотой нийтлэл бичих, нийгэмд болж бүтэхгүй байгаа болон болж байгаа зүйлийн талаар өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, өөрийн сонирхлын дагуу бусдад хэрэгцээтэй мэдээлэл хүргэх болон өдрийн тэмдэглэл хөтлөх ч боломжтой. Блогийн хувьд маш олон блогийн үйлчилгээ үзүүлдэг компани дэлхийн хэмжээнд болон Монголд олон бий.

Блог нь энэ мэт “хэвлэл мэдээллийн хэрэгсэл”-ийн үүргийг гүйцэтгэх хэдий ч албан ёсны “хэвлэл мэдээллийн хэрэгсэл” биш тул мэдээллийн үнэн байдлын, хэл найруулга, хэлний хэм хэмжээний талаасаа хариуцлага хүлээлгэх боломжгүй төдийгүй шаардлагагүй хэрэгсэл юм. Гэвч блог нэлээд олныг хамарсан идэвхтэй хэрэгсэл байсан бол сүүлийн үед нийгмийн сүлжээний бусад сайтуудын нөлөөгөөр эрч хүч нь эрс суларчээ.

### **Интернэт хэл шинжлэл ба монгол хэл шинжлэлийн ухаан**

Нийгмийн шинжлэх ухааны салбарт хамаардаг томоохон судалгааны чиглэл бол хэл шинжлэл юм. “Хүн төрөлхтөний хэл, түүний гарал үүсэл, мөн чанар, үүрэг, түүнчлэн дэлхийн олон хэлний бүтэц, тогтолцоо, хөгжил, зүй тогтол, төрөл, хэв маягийг судалдаг шинжлэх ухааныг хэл шинжлэл гэнэ” (Томтогтох, 2009: 11). Хэл шинжлэлийн түүхийн хувьд хэлийг судалдаг шинжлэх ухаан бий болсноос хойш олон үзэл баримтлал бий болон нарийсан хөгжсөөр иржээ. Тухайлбал, хэл шинжлэл орчин үед дараах гурван чиглэлээр хөгжиж байна:

1. Онолын хэл шинжлэл (Theoretical linguistics)
2. Тодорхойлох хэл шинжлэл (Descriptive linguistics)
3. Хавсарга хэл шинжлэл (Applied linguistics)

Хавсарга хэл шинжлэлийн салбарын нэгэн шинэ чиглэл бол интернэт хэл шинжлэл билээ. Монгол хэл шинжлэлийн түүхийн хувьд нэлээд сонирхолтой, баялаг цаг үе гэвэл өнөөгийн энэ цаг үеийг хэлж болно. Учир нь хэдий хэл шинжлэлийн ухаан хөгжсөөр ирсэн олон зуун жилийн түүхтэй хэдий ч хүний нийгмийн өөрчлөлт хувьсал, техник технологийн хувьслыг дагаад судалгааны шинэ чиглэлүүд бий болсоор байгаагийн нэгэн жишээ нь интернэт хэл шинжлэл билээ. Энэ талаар “Хэл бол алгуурхан боловч хувьсан өөрчлөгдөж байдаг нийгмийн маш нарийн системтэй үзэгдэл юм. Гэвч тэгж өөрчлөгдөн хувьсах зуураа хэлбэржин хэвшиж байдаг ажээ” хэмээн нэрт хэл шинжээч Ш.Лувсанвандан хэлсэн байдаг.

Эх орны монгол хэл шинжлэлийн өнөөгийн өвөрмөц цаг үеийн тухайд академич Л.Болд “Ром-Европын хэл шинжлэлийн уламжлалт арга болон бүтэцзүйн аргад тулгуурласан манай ахмад үеийнхний хийсэн судалгаа шинжилгээний ажлын үр дүнд монгол хэл судлал жигд хөгжсөн салбар ухаануудаас бүрдсэн бүхэл бүтэн тогтолцоотой, үндэсний шинжлэх ухаан болон хөгжих бололцоо нь бүрдэв. Иймээс энэ л үеэс эхлэн тусгай буюу тодорхой онцолсон асуудлыг биш монгол хэлний бүхий л үзэгдлийг нарийвчлан судлах судалгааны аргагүй нэлээд боловсронгуй болж, зарим салбарт баримт материалыг өмнөх үеүдтэй харьцуулшгүй ихээр бүрдүүлж чадсан нь цаашид эрдэм судалгааны ажлыг хийх аятай боломж олгосон билээ” (Болд, 2012: 7) хэмээсэн байдаг бөгөөд монгол хэлний бүхий л үзэгдлийг нарийвчлан судлах ажил ийнхүү интернэт хэл шинжлэлийн судалгаагаар үргэлжилж байна.

**Дүгнэлт**

Хэл бол зогсонги зүйл биш байнга хувьсаж өөрчлөгдөж байдаг зүйл билээ. Хэлний энэхүү зогсонги биш байгааг харуулах нэг талбар нь эдүгээ интернэтийн орчин болж байна. Интернэтээр явагдаж буй мэдээллийн энэ их урсгал мэдээж хэлээр дамжина. Монголын интернэт хэл шинжлэлийн судлагдахууныг улам гүнзгийрүүлэн судлах, судалгааны цар хүрээг өргөжүүлэн хэлэнд илрэн гарч буй онцлогуудыг тодруулах зэрэг нь Монголын интернэт хэл шинжлэлийн судалгааны гол зорилт юм.

### Ном зүй

1. **Бат-Ирээдүй, Ж.** 2011. Твиттер ба монгол твиттерчид. <http://iregedui.blogspot.com/search/label/Твиттерийн%20тэмдэглэл>
2. **Болд, Л.** 2012. *Монгол хэл шинжлэлийн түүхийн асуудлууд*. Уб
3. **Болд-Эрдэнэ, Б.** 2009. *Интернэт сэтгүүл зүй*. Уб
4. **Интернэт.** 2006. Бүрэн хэмжээний гарын авлага. Уб
5. **Монгол улсын өрсөлдөх чадварын тайлан 2014.** 2015. Уб
6. **Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мониторингийн судалгаа.** 2013. Монголын хэвлэлийн хүрээлэн. Уб
7. **Томтогтох, Г.** 2009. *Хэл шинжлэлийн удиртгал*. Уб
8. **Цагаан ном.** 2014. *Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарын хөгжил*. Уб
9. **Энхбат, Д.** 2008. Монголд интернэт нэвтрүүлсэн түүх. <http://www.enkhbat.mn/2008/10/монголд-интернэт-нэвтрүүлсэн-түүх.html>
10. **Энхмаа, Б.** 2015. *Интернетийн хэл шинжлэл*. Уб., Соёмбо принтинг ХХК. 161 х.
11. **Эх сурвалж: Монгол улсын өрсөлдөх чадварын тайлан 2014.** 2015. Уб
12. **World Internet Users and 2015 Population Stats.**2015. <http://www.internetworldstats.com/stats.htm>
13. [https://en.wikipedia.org/wiki/List\\_of\\_virtual\\_communities\\_with\\_more\\_than\\_100\\_million\\_active\\_users](https://en.wikipedia.org/wiki/List_of_virtual_communities_with_more_than_100_million_active_users)
14. <http://www.statisticbrain.com/twitter-statistics/>

### SUMMARY

*Distinctions of modern communication tools, social networks and online journalism are written in this article. It is noted how social network sites and online journalism are depended of Mongolian language. Websites for public are official news media. Therefore, Mongolian language norm must be obeyed in these official websites. Whereas, social network sites (Facebook, Twitter etc.) are private communication tools. Thus, Mongolian language norm must not be obeyed in these social network sites.*